



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/562

Алтай хот

“Улсын хил хамгаалалтад туслах
хүчний зөвлөл” байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар баталсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэд “Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийг (цаашид “Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл” гэх) байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж, аймгийн Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлтэй хамтран ажиллах “Улсын хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл”-ийг (цаашид “УХХТХСЗ” гэх) байгуулж ажиллахыг Алтай, Бугат, Цогт, Тонхил, Эрдэнэ сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3.Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх ажлыг жил бүр төлөвлөгөө гарган зохион байгуулж ажиллахыг Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т, Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн орлогч дарга, Хилийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа В.Батжаргал)-д тус тус даалгасугай.

4.Улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардлыг төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дугаар сарын 19-ны өдрийн 1156 дугаар
захирамжийн хавсралт

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:
Орлогч дарга:
Гишүүд:

- (Аймгийн Засаг дарга)
- (Хилийн 0214 дүгээр ангийн захирагч)
- (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)
- (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
- (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- (Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
- (Аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч)
- (Аймгийн Прокурорын газрын дарга)
- (Аймаг дахь Цагдаагийн газрын дарга)
- (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
- (Тагнуулын Ерөнхий газрын аймаг дахь хэлтсийн дарга)
- (Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)
- (Говийн их дархан цаазат газрын "А" хэсгийн хамгаалалтын захиргааны дарга)
- (Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны дарга)
- (Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг дарга)
- (Алтай сумын Засаг дарга)
- (Бугат сумын Засаг дарга)
- (Цогт сумын Засаг дарга)
- (Тонхил сумын Засаг дарга)
- (Эрдэнэ сумын Засаг дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: